

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР ОХУ-Д АЛБАН ЁСООР АЙЛЧИЛСАН ДҮНГИЙН ТУХАЙ ХАМТАРСАН АЛБАН МЭДЭЭ

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр ОХУ-ын Засгийн газрын дарга М.М.Касьяновын урилгаар 2003 оны 6-р сарын 26-наас 7-р сарын 3-ны өдрүүдэд ОХУ-д албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр ОХУ-ын ОХУ-ын Засгийн газрын дарга М.М.Касьяновтай хэлэлцээ хийж, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинд бараалхав.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярыг ОХУ-ын Холбооны хурлын Холбооны Зөвлөлийн дарга С.М.Миронов, Төрийн Думын дарга Г.Н.Селезнёв нар хүлээн авч уулзав.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр ОХУ-ын Чита, Эрхүү, Кемеровт зочилж, эдгээр мужийн захирагч нартай уулзав.

Найрсаг байдалд болсон уулзалт, хэлэлцээний үеэр хоёр талын харилцааны тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж, харилцан сонирхсон олон улсын зарим асуудлаар санал солилцлоо. Сайн хөршийн уламжлалт түншлэлд багтай тулгуурласан Монгол, Оросын харилцааны онцгой шинж чанар түүхэн шинэ нөхцөлд ч халгалагдаж байгааг цохон тэмдэглэв. Монгол, Оросын түншлэлийн агуулга нь улс төрийн хувьд - тэгш эрх, итгэлцэл, хүндэтгэлд үндэслэсэн харилцан ажиллагаа байх бөгөөд эдийн засгийн хувьд хоёр оронд хэрэгжүүлж буй зах зээлийн шинэчлэлийг харилцан дэмжиж, худалдааг тууштай либералчлах, хөрөнгө оруулалтын салбарт үр өгөөжтэй хамтран ажиллах, бүс нутгийн болон хил орчмын төвшинд хэлхээ холбоог гүнзгийрүүлэх, олон талын интеграцийн төслүүдэд орлцох замаар хоёр талын худалдаа-эдийн засгийн харилцааг өргөжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх, хүмүүнлэгийн салбарт-соёл шинжлэх ухаан-техник, боловсролын салбаруудад дахь өргөн хамтын ажиллагаа, иргэд, олон нийтийн байгууллагуудын хоорондын харилцааг дэмжих явдал байна.

1993 оны 1-р сарын 20-нд гарын үсэг зурсан Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ болон 2000 оны 11-р сарын 14-ний “Улаанбаатарын Тунхаглал” нь орших чадвартай бөгөөд хоёр улсын үндэсний эрх ашигт урт хугацаанд нийцсэн болохыг тэдгээрт гарын үсэг зурснаас хойшхи цаг хугацаа нотлон харуулж буйг Засгийн газрын тэргүүн нар тэмдэглэв. Эдгээр үндсэн баримт бичгийг цаашид тодорхой агуулгаар баяжуулах талаар хийж буй арга хэмжээ, алхмуудын талаар хэлэлцэв.

Хоёр талын харилцааны гол гогцоо асуудлуудыг хэлэлцээд, тохиролцсон тодорхой алхмуудыг Засгийн газрын тэргүүн нарын уулзалтын үеэр сайшааж, энэхүү албан мэдээнд хавсаргаж буй “худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын харилцааг 2002-2004 онд идэвхжүүлэх талаар Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгасан болно.

Худалдааг харилцан либералчлах асуудлыг ДХБ-д Орос улс элсэх бэлтгэл ажилтай уялдуулан авч үзэх, тухайлбал, Монголын экспортын бараанд Оросын талаас ноогдуулж буй гаалийн болон бусад татвар, Монголоос ачигдсан болон дамжин өнгөрөх ачааны тээвэрлэлтийн тариф, Монгол руу Оросоос нийлүүлэх цахилгаан эрчим хүчний үнэ, тарифыг бууруулах, Монголын мах, махан бүтээгдхүүн, түүнчлэн Оросоос нийлүүлэх нефть бүтээгдхүүний тарифын бус хязгаарлалтыг багасгах зэрэг асуудлаар Монголын талаас дэвшүүлсэн саналуудаар харилцан хүлээн авахуйц шийдэлд хүрэх нь хоёр талын худалдаа-эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх чухал үүрэг гүйцэтгэнэ гэдгийг талууд тэмдэглэв.

Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдийн үндсэн дээр урьд өмнө байгуулагдсан “Эрдэнэт” УБҮ, “Монголросцветмет” болон “УБТЗ” ХК зэрэг хамтарсан үйлдвэрүүдийн үйл ажиллагааны талаар санал солилцож, хоёр орны харилцаан дахь тэдгээрийн ач холбогдол, Монголын эдийн засагт үзүүлж буй чухал нөлөөг тэмдэглэв. Монгол-Зөвлөлтийн хамтарсан “Эрдэнэт” үйлдвэрийн үйл ажиллагааны талаарх Засгийн газар хоорондын 1991 оны 6-р сарын 5-ны өдрийн хэлэлцээрийн хугацаа дууссантай холбогдуулан талууд уг хэлэлцээрийн хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгүүдийн хэлэлцээний явцын талаар ярилцаад, харилцан хүлээн авахуйц нөхцлөөр холбогдох хэлэлцээрийг байгуулав.

Монгол Улсад хуучин ЗХУ-аас шилжих рублиэр олгосон зээлийн ерийн асуудлыг зохицуулах хэлэлцээний дүнг авч үзээд 2000 оны 11-р сард Монгол Улсад ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины хийсэн айлчлал болон 2002 оны 3-р сард Засгийн газрын тэргүүнүүдийн түвшинд хийсэн хэлэлцээний үеэр тохирсон ерөнхий зарчмуудыг удирдлага болгон холбогдох Меморандумд гарын үсэг зурав.

Талууд хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг бүх талаар өргөжүүлэхийн ач холбогдлыг цохон тэмдэглэв. Монголын тал бизнесийн эрх зүйн оновчтой орчин бүрдүүлэх талаар явуулж буй

бодлогынхоо тухай мэдээлж, Монголын эдийн засгийн төрөл бүрийн салбарт Оросын хөрөнгө оруулалтыг түлхүү оролцуулах сонирхолтой байгаагаа илэрхийллээ. Үүнтэй холбогдуулан, ашигт малтмалын томоохон орд газруудыг эзэмших болон Монголын дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах асуудлуудыг хэлэлцэв. Монголд ахуйн хийг ашиглах чиглэлээр хамтран ажиллахыг ирээдүйтэй гэж үзэв.

Монгол дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн асуудлаархи хамтарсан ажлын хэсгийн гүйцэтгэсэн ажлыг сайшааж байгаагаа талууд тэмдэглэв. Ерөнхий сайд Н.Энхбаяр Монгол Улсад байнга оршин суугаа ОХУ-ын иргэдэд эзэмшиж буй орон сууцыг нь үнэ төлбөргүй хувьчлах тухай Монголын талын гаргасан шийдвэрийг нотлоод, Монгол Улсын Гадаад Хэргийн Яамны холбогдох ноотод Оросын талын хүсэлтээр өөрчлөлт оруулсныг мэдэгдэв. ОХУ-ын Засгийн газрын дарга М.М.Касьянов үүнд талархал илэрхийлэхийн хамт үүний хариу алхам болгож, Монголын нутаг дахь ОХУ-ын өмчийн орон сууцны зарим байшинг Монголын талд үнэ төлбөргүйгээр шилжүүлж өгөхөд Оросын тал бэлэн байгаагаа мэдэгдэв.

Соёл, шинжлэх ухаан, боловсролын салбар дахь хамтын ажиллагаа болон хүмүүнлэгийн харилцааны бусад асуудалд онцгой анхаарал хандуулав. Монголын боловсон хүчнийг Оросын их, дээд сургуулиудад бэлтгэх нь хоёр орны харилцаа хамтын ажиллагааны хөгжилд зарчмын ач холбогдолтойг Н.Энхбаяр цохон тэмдэглээд, ОХУ-д манай оюутнуудыг хөнгөлттэй нөхцлөөр сургаж байгаа болон урлаг, соёл, анагаах ухааны чиглэлээр суралцах оюутнуудад улсын тэтгэлэг олгох болсонд талархал илэрхийллээ. Талууд аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагаа хөгжүүлэх сонирхлоо харилцан илэрхийлэв.

Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын ЗГХК-ын ажлыг Засгийн газрын тэргүүн нар сайшааж, үйл ажиллагаа нь мэдэгдэхүйц идэвхжсэнийг тэмдэглэв. Үүний зэрэгцээ ЗГХК-ын хуралдаануудын шийдвэр, зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хангах талаар холбогдох яам, газруудад үүрэг өгч, зарим дэд комисс, ажлын хэсгүүдийн ажлын үр дүнг дээшлүүлэх шаардлагатайг тэмдэглэв.

Монгол-Оросын хоорондын худалдааны бараа эргэлтийн 70 орчим хувийг эзэлж буй хил орчмын болон бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд талууд чухал ач холбогдол өгч байна. Энэ чиглэлээр хийгдэж байгаа ажлууд, түүний дотор бүс нутаг, хил орчмын

хамтын ажиллагааны дэд комиссын үйл ажиллагаанд хоёр орны Засгийн газар шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлж байх болно. Хил орчмын нутагт аюултай, онцгой байдал /түймэр, халдварт өвчин зэрэг/ үүсэх буюу заналхийлэх тохиолдолд шаардлагатай асуудлыг шуурхай шийдвэрлэх, уршгийг арилгах үүднээс мэдээлэл солилцох байгууллага хоорондын хамтарсан мониторингийн тогтолцоог бий болгох нь оновчтой гэж үзэв.

Талууд хоёр орны хоорондын цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагааг идэвхжүүлэхээр тохиролцов.

Олон улсын харилцааны тулгамдсан чухал асуудлуудаар санал солилцох явцад үндсэн хандлагууд ойролцоо буюу тохирч байгааг тэмдэглэв. Талууд Зүүн Хойд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааг хоёр болон олон талын харилцааны үндсэн дээр өргөжүүлэхийн төлөө байна.

Айлчлалын үеэр дараах баримт бичгүүдэд гарын үсэг зурав. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хооронд Соёл, шинжлэх ухаан, боловсролын салбарт 2003-2006 онд хамтран ажиллах тухай хөтөлбөр,

- Боловсролын баримт бичиг, эрдмийн зэрэг, эрдмийн цолыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр,

- Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр,

- Монгол Улс, ОХУ-ын хоорондын Консулын Конвенцийг соёрхон баталсан тухай батламж жуух бичгүүдийг солилцох тухай Протокол болох бусад баримт бичгүүд.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярыг ОХУ-д халуун дотноор хүлээж авлаа.

Ерөнхий сайд Н.Энхбаяр ОХУ-ын Засгийн газрын дарга М.М.Касьяновыг тааламжтай цагтаа Монгол Улсад айлчлан ирэхийг урив. Урилгыг талархан хүлээж авлаа.

Монгол Улсын Ерөнхий сайд
Н.Энхбаяр
ОХУ-ын Засгийн газрын дарга
М.М.Касьянов